

БАТЛАВ.

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Н.УЧРАЛ

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн нь татварын хуулийн хэрэгжилтэд татвар төлөгчийн оролцоотойгоор хяналт тавих, татвар төлөгчийг урамшуулах, бүртгэл, хяналтын тогтолцоог сайжруулах замаар бизнест ээлтэй, тэгш шударга өрсөлдөх орчныг бий болгох, далд эдийн засгийг бууруулахад ихээхэн ач холбогдолтой алхам болсон билээ.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.11-д “Татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааг цахимжуулж, ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар татварын үйлчилгээг иргэд, татвар төлөгчдөд хүндрэлгүй болгож, татварын суурийг нэмэгдүүлнэ.”, 6.2.5-д “Бүсийн хөгжлийн бодлоготой уялдуулан татварын шаталсан тогтолцоог хөгжүүлж, орон нутаг томоохон аж ахуйн нэгж салбараа байгуулахыг бодлогоор дэмжинэ.” гэж тус тус заасан.

Мөн Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд 4.2-т “Шинэ суурьшлын бүс, дагуул хот, эдийн засгийн чөлөөт бүсийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, Улаанбаатар хотоос орон нутаг шилжин суурьшсан иргэд, аж ахуйн нэгжүүдийг цогц бодлогоор дэмжих замаар төвлөрлийг сааруулна.” гэж заасан.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт албан татвар төлөгчид тодорхой хэмжээний урамшуулал олгож байхаар заасан бөгөөд хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасан албан татвар төлөгчийн тухайн татварын жилд албан татвар суутган төлөгчтэй хийсэн худалдан авалтад төлсөн албан татварын 20 хүртэлх хувийг буцаан олгохоор, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.13 дахь хэсэгт буцааж олгох албан татвар болон урамшуулал нь улсын төсвийн бүрэлдэхүүн хэсэг байх бөгөөд тухайн сар, улирал, жилд улсын төсөвт төвлөрүүлэх тухайн төрлийн татварын 30 хувиас хэтрэхгүй байхаар хуульчлагдсан болно.

Татварын алба 2021 онд 2.8 их наяд төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татварын орлого улсын төсөвт төвлөрүүлжээ. Энэ нь 2015 онтой харьцуулахад 1.8 их наяд төгрөгөөр нэмэгдсэн буюу 2.7 дахин өсөөд байна. Харин Монгол Улсын ДНБ 2021 онд 43 их наяд байсан бол 2015 оноос 1.88 дахин өссөн юм. Нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын өсөлтийн хэмжээ ДНБ-ний өсөлтөөс даруй 1.93 дахин буюу 82 хувиар илүү байгаа нь далд эдийн засгийг бууруулах зорилго зорилтдоо хүрч байгаагийн илрэл гэж үзэж болохоор байна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд заасны дагуу албан татварын 20 хүртэлх хувийг буцаан олголтын урамшуулал хэлбэрээр 2019 онд 237.2 тэрбум 2020 онд 351.8 тэрбум, 2021 онд 294.7 тэрбум төгрөгийг тус тус иргэдэд олгосон байна.

Монгол Улсын Сангийн яамны тооцооллоор 2021 онд эдийн засгийн 33 хувь нь далд байгаа бөгөөд 2017 онд 45 хувь нь татвараа төлдөг байсан бол Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар НӨАТ-ын баримтын системийг 2017 оноос нэвтрүүлснээр өнөөдөр 67 хувьд хүрсэн гэж үзсэн байна.

Дээрх судалгаанаас үзэхэд нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын өсөлтийн хурд саарч, цаашид нэмэлт арга хэмжээ авахгүй байх тохиолдолд далд эдийн засгийг бууруулах зорилго зогсонги байдалд орох магадлалтай байна.

Ковид-19 цар тахлын нөлөөгөөр бий болсон хил дамнасан тээврийн хүндрэлтэй нөхцөл байдал болон өргөн хэрэглээний барааны үнийн өсөлт иргэдийн амжиргаанд сөргөөр нөлөөлж байгаа ба Монголбанкны статистик мэдээллээр улсын жилийн инфляцын түвшин 2022 оны 2 дугаар сарын байдлаар 14.2 хувьд хүрч, 2014 оноос хойш анх удаа 10 хувийг даваад байна.

Үндэсний статистикийн хороо, Дэлхийн банкнаас Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдалд хийсэн судалгаагаар ядуурлын түвшин 2014 онд 21.6 хувь, 2016 онд 29.6 хувь, 2018 онд 28.4 хувь, 2020 онд 27.8 хувь байжээ. Ядуурлын хэмжээний бууралт хангалтгүй байгаа ба хэрвээ ковид-19 цар тахал дэгдээгүй байсан бол 3 орчим нэгж хувиар буурахаар байсан гэж дүгнэжээ.

Мөн ядуу амьдралтай иргэдийн тоо буурахгүй байгаа ба хүн амын 51.5 хувь нь ямар нэгэн төрлийн зээлтэй, нийгэм, эдийн засагт сөрөг цочрол үүсэхэд олон тооны иргэд ядууралд гулсан орох эмзэг байдалтай байна гэжээ.

Иймд нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын хувийг нэмэх замаар өргөн хэрэглээний барааны үнийн өсөлттэй холбоотойгоор иргэдэд ирж буй үнийн дарамтыг 2-4 хувиар бууруулах, нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн тооны өсөлтийг нэмэгдүүлэх, улмаар далд эдийн засгийн хэмжээг багасгах, хот болон орон нутагт буцаан олголтын хэмжээг ялгавартай байдлаар тогтоож хөдөө, орон нутаг руу шилжих хөдөлгөөнийг бодлогын хувьд дэмжих боломжтой гэж үзэж байна.

Хоёр. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн бүтэц, агуулга

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь 3 зүйлтэй.

Хуулийн төсөл нь нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын хэмжээ 20 хувь байгааг өргөн хэрэглээний бараанд Улаанбаатар хотод 40 хувь, орон нутагт 60 хувь болгох ба өргөн хэрэглээний барааны жагсаалтыг Засгийн газар батлахаар зохицуулалт нэмж тусгана.

Мөн хууль хүчин төгөлдөр болох хугацааг 2022 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс байхаар заана.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагаврын талаар

Хуулийн төсөл батлагдсанаар иргэдийн зүгээс байгууллага, аж ахуйн нэгжид тавих хяналт сайжирч, татварын орлогын бааз суурь өргөжих боломж бүрдэнэ. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт сайжирч, улсад төвлөрөх татварын хэмжээ нэмэгдэх нь иргэдэд олгох буцаан олголтын хэмжээг төсөвт дарамт багатайгаар нэмэгдүүлэх боломжийг бий болгох боломжтой.

Цаашилбал далд эдийн засгийг бууруулах арга хэмжээ идэвхэжсэнээр бизнесийн шударга өрсөлдөөний орчин сайжирч иргэд, аж ахуйн нэгжийн бизнес хийх сонирхол дээшлэх, татварын тэгш, шударга байх зарчим хангагдана. Улмаар олон улсын жишигт нийцсэн тогтвортой татварын орчинг бий болно гэж үзэж байна.

Түүнчлэн нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын хувь хэмжээг нийслэл болон орон нутагт ялгавартай тогтоосноор хөдөө, орон нутагт амьдарч буй иргэдэд тодорхой дэмжлэг болох болно.

Дөрөв. Хуулийн төсөл нь бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Хуулийн төслийг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулиудтай нийцүүлэн боловсруулах бөгөөд уг төсөл нь тэдгээртэй зөрчилдөхгүй. Хуулийн төсөл батлагдсанаар бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй болно.

---oOo---